



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2018 оны 01 сарын 09 өдөр

Дугаар 03

Мандалговь

Хөрөнгө акталж худалдах тухай

Монгол улсын "Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль"-ийн 77 дугаар зүйлийн 77.2.3, 77.3 заалт, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 232 дугаар тогтоолоор батлагдсан "Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн харилцааг зохицуулах журам"-ын 2.1.7, 5.8.а дахь заалтыг тус тус үндэслэн Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Дэлгэрхангай сумын Эрүүл мэндийн төвийн үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 12,978,685.00 /Арван хоёр сая есөн зуун далан найман мянга зургаан зуун наян таван төгрөг/-ний анхны өртөгтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 36-62 ДУА улсын дугаартай УАЗ-31512маркын автомашиныг актлан худалдахыг зөвшөөрсүгэй.

2. Хөрөнгө худалдах үнийн доод хязгаарыг 2,000,000.00 /Хоёр сая төгрөг/-өөр тогтоон нийтийн дуудлага худалдааг журмын дагуу зохион байгуулж, хөрөнгө худалдсанаас орох орлогыг 100 хувь Төрийн сангийн хөрөнгө борлуулсны орлогын 100080000962 тоот дансанд төвлөрүүлэхийг Орон нутгийн өмчийн газар /С.Ууганбаяр/-т үүрэг болгосугай.

3. Эд хөрөнгийг худалдсаны дараа холбогдох хууль журмын дагуу данс бүртгэлээс хасахыг Дэлгэрхангай сумын Эрүүл мэндийн төв /Э.Саруулжаргал/-д даалгасугай.

4. Тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга Ц.Мөнгөнцэожид үүрэг болгосугай.

ДАРГА С.СҮХБААТАР



0100004